

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дэлгэрмөрөн сум дундын ойн анги” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/015/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас: www.audit.mn Хөвсгөл аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Давааням Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор: Б.Пүрэвсүрэн Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 21/293
танай _____ -ны № _____ -т

“ДЭЛГЭРМӨРӨН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИ” ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ЛХАЧИНБАТ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дэлгэрмөрөн сум дундын ойн анги” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Дэлгэрмөрөн сум дундын ойн анги” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 11,099.9 мянган төгрөгийн түймрийн багаж хэрэгсэл, 105,894.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 9,575.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 23,668.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 22,523.7 мянган төгрөгийн, төсөв зарцуулалттай холбоотой 1,144.3 мянган төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 65 арга хэмжээтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,615,884.96	20,889,460.88
1.1.02	Дансны авлага	12,953,945.24	25,015,00.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	2,315,594.07
1.1.04	Бусад авлага	0.00	0.00
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.06	Бараа материал	14,872,052	28,333,438
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	0.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,441,882.20	76,553,492.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.01	Үндсэн хөрөнгө	13,077,157.99	187,052,112.53
1.2.02	Биет бус хөрөнгө	14,750,000.00	8,850,000.00
1.2.03	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,827,157.99	195,902,112.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	69,269,040.19	272,455,605.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	3,726,688.31	890,804.95
2.1.1.02	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.03	Татварын өр	472,018.84	0.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.05	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.06	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,198,707.15	890,804.95
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.01	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00

2.1.2.05	Хойшлогдсон орлого	0.00	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,198,707.15	890,804.95
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.01	Өмч: - төрийн	3,984,000.00	3,984,000.00
2.3.02	- хувийн	0.00	0.00
2.3.03	- хувьцаат	0.00	0.00
2.3.04	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	200,862.90	200,862.90
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	15,195,441.40	15,195,441.40
2.3.09	Хуримтлагдсан ашиг	45,690,028.74	252,184,496.23
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-6,080,122.11	206,498,591.13
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	39,609,906.63	45,685,905.1
2.3.11	Эздийн өмчийн дүн	65,070,333.04	271,564,800.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	69,269,040.19	272,455,605.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	207,694,000.00	609,409,110.10
02	Борлуулалтын өртөг	4,266,500	9,703,800.00
03	Нийт ашиг(алдагдал)	203,427,500.00	599,705,310.10
04	Үйлчилгээний орлого	103,309,000.00	78,253,358.10
05	Хүүний орлого	0.00	0.00
06	Санхүүжилтын орлого	104,385,000.00	364,792,000.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	0.00
08.1	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	0.00	166,363,752.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	209,473,222.11	367,591,936.84
11	Санхүүгийн зардал	34,400.00	57,300.0
12	Бусад зардал	0.00	6,792,500.00
12.1	Зардлын дүн	209,507,622.11	374,441,736.84
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	-14,750,000.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-6,080,122.11	210,513,573.26
19	Орлогын татварын зардал	0.00	4,014,982.13
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-6,080,122.11	206,498,591.13
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-6,080,122.11	206,498,591.13
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	203,529,500.00	423,652,058.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	98,376,500.00	52,340,100.00
1.1.2	Авлага барагдуулсны орлого	768,000.00	5,575,200.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	104,385,000.00	364,792,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	944,758.10
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	203,226,134.68	306,948,782.18
1.2.1	Ажиллагчдад төлсөн	113,982,769.49	153,312,384.54
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,706,483.39	43,542,780.20
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,164,256.00	7,240,952.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,276,200.00	18,436,700.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	12,606,325.80	21,823,264.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	277,800.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	29,490,100.00	62,044,901.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	303,365.32	116,703,275.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	109,429,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	109,429,700.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-109,429,700.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	303365.32	7,273,575.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,312,519.64	13,615,884.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,615,884.96	20,889,460.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	19,179,441.40	33,609,027.31	0.00	27,403,595.80	46,583,037.20
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	21,048,560.20	21,048,560.20
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	-2,766,250.90	-2,766,250.90
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	19,179,441.40	200,862.9	0.00	45,685,905.10	65,066,209.40
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	206,498,591.13	206,498,591.13
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	19,179,441.40	200,862.9	0.00	252,184,496.23	271,564,800.53

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

	Үзүүлэлт	2025		Харьцуулалт	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	НИЙТ ОРЛОГО	524,622,160.00	609,409,110.10	116.2	-84,786,950.10
2	НИЙТ ЗАРДАЛ	336,670,870.00	398,895,536.84	118.48	-62,224,666.84
	Үүнээс: Удирдлагын зардал	35,459,520.00	36,501,336.50	102.94	-1,041,816.50
3	Татварын өмнөх ашиг	187,951,290.00	210,513,573.26	112.00	-22,562,283.26
4	Цэвэр ашиг /алдагдал/	169,156,161.00	206,498,591.13	122.08	-37,342,430.13
5	Төсвийн төлбөрт нийт дүн	230,412.90	198,604.10	86.19	31,808.80

	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	18,795,129.00	4,014,982.13	21.36	14,780,146.87
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.00	0.00		0.00
	Ус ашигласны төлбөр	0.00	0.00		0.00
	Газрын төлбөр	85,000.00	17,700.00	20.82	67,300.00
	Агаарын бохирдлын төлбөр	0.00	0.00		0.00
	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	57,000.00	57.58	42,000.00
	ЭМНДШ	23,259,200.00	22,539,207.20	96.90	719,992.80
	Үл хөдлөхийн татвар	0.00	0.00		0.00
	ХАОАТ	16,889,040.00	15,427,925.42	91.35	1,461,114.58
	Бусад	0.00	0.00		0.00
6	Төрийн өмчийн ноогдол ашигт	0.00	0.00		0.00
7	Нийт ажиллагсдын тоо	5.50	5.50	100.00	0.00
8	Нийт цалингийн сан	186,073,600.00	171,629,780.18	92.24	14,443,819.82
9	Нэг ажилтны дундаж цалин	1,938,266.67	1,787,810.21	92.24	150,456.46
10	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	0.00	0.00		0.00
11	Хөрөнгө оруулалт	112,506,000.00	111,079,700.00	98.73	1,426,300.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,668.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээр, 10,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад баталгаажуулан залруулсан, 800.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 344.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Залруулсан алдаа:

- Төрийн сангаас авах 10,000.0 мянган төгрөгийг нэхэмжлэх шивж орлогоор бүртгэн орлого илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" гэсэн заалтууд зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1 Төлбөрийн акт

- Тус байгууллага нь ажилчдын нийгмийн баталгааг хангах үүднээс байгууллагын даргын тушаалаар 800.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг ажилчдын судалгаа хийлгүй орон сууцанд амьдардаг ажилчдад өгсөн байна. Энэ нь Хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх гэсэн заалтуудын дагуу урьдчилсан тооцоолол зохих шаардлагыг хангуулан туслах үйл ажиллагаанаас олох орлогыг зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 12 523.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 13 нэр төрлийн 33 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалт зөрчигдөж ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.

2.Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээр цалин 344.3 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингын хүснэгтээрх тооцоолсон дүнг үнэн зөвөөр тайлагнах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

“Дэлгэрмөрөн сум дундын ойн анги” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Газрын эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй бүртгэсэн байна.	1	5,900.0							1	5,900.0
Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	20,322.6					1	20,322.6		
Үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жилийн тооллого хийгдээгүй, эд хөрөнгө хариуцагчийн картыг баталгаажуулаагүй байна.	1	32,383.9					1	32,383.9		
Тээврийн хэрэгсэл бүртгэлд тусгаагүй байна.	1	-					1	-		
Дансны бичилт буруу хийгдсэн.	1	6,028.9							1	6,028.9
Төндөрийн материал шаардлага хангаагүй байна	1	18,000.0					1	18,000.0		
Шилэн дансанд тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	-					1	-		
Нийт дүн	7	82,635.5					5	70,706.6	2	11,928.9

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Төрийн сангаас авах 10 000.0 мянган төгрөгийг нэмхэмжлэх шивж орлогоор бүртгэн орлого илүү тайлагнасан байна.	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
Дүн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага				Тоо	Дүн
Тус байгууллага нь ажилчдын нийгмийн баталгааг хангах үүднээс байгууллагын даргын тушаалаар 800.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг ажилчдын судалгаа хийлгүй орон сууцанд амьдардаг ажилчдад өгсөн байна.	1	8,00.0	1	800.0						
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 12 523.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 13 нэр төрлийн 33 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	12,523.8							1	12,523.8
Цалин зөрүүтэй тайлагнасан байна.	1	344.3							1	344.3
Дүн	3	13,668.1	1	800.0					2	12,868.1

